



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 02 сарын 14 едер

Дугаар A-35

Улаанбаатар хот

"Евразия Капитал Холдинг УЦК" ХК-ийн  
арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11, Гишүүнчлэлийн журмын 5 дугаар зүйлийн 5.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гүйцэтгэх захирлын А-31 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрх нь хязгаарлагдсан "Евразия Капитал Холдинг УЦК" ХХК-ийн арилжаанд оролцох эрхийг 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. Тус компаниас ирүүлсэн албан хүсэлтэд дурдсан нэмэлт хувьцаа гаргахтай холбоотой 2016 онд төлсөн төлбөр хураамжаас 2017 оны Гишүүнчлэлийн хураамжид зохих хэсгийг суутган тооцож тооцоо нийлсэн акт үйлдэхийг Захиргаа, санхүүгийн газрын Санхүүгийн алба /Б.Ганбат/-нд даалгасугай.
3. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулалтын газрын Хяналт, шалгалтын алба /Д.Баттулга/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ